



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор сумын 2 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/56/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2020 он</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: Munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: О.Алтансүх Утас: 99077045 Цахим хаяг: Altansukho52@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.13. Шилэн дансны мэдээлэл	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	10
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
Менежментийн захидал	11
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	13
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	13
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	14
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	18
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	18



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНХОНГОР СУМЫН 2 ДУГААР Г
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
С.ШҮРЭНЦЭЦЭГ ТАНАА

Сүрэнцэцэг № *1/203*
танай _____ -ны № _____ -т
Г _____ Г

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор сумын 2 дугаар цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Баянхонгор сумын 2 дугаар цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул "Хязгаарлалттай" санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор сумын 2 дугаар цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус салбарт мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:/бичиг хэрэг 2020-Албан тоот А4/

• 005020216

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

Гүйцэтгэсэн горим сорилын дүнд илэрсэн алдаа, зөрчлийн дүн нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшингээс хэтэрсэн, тооллого хийсэн боловч, нягтлан бодогч тооцоог бодож акт үйлдээгүйгээс 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн бараа материалын тодруулгын дүн нярвын бараа материалын дүнгээс нийт 24,6 сая төгрөгийн зөрүүтэй байгаагаас санхүүгийн тайлан үнэн зөв эсэхийг нотлох боломжгүй байна.

Дээрх алдаа, зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-т " Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалтыг зөрчиж, санхүүгийн тайлангийн толилуулгын Оршин байх, Эрх ба үүрэг, Иж бүрэн байх, Үнэлгээ, Хэмжилт, Толилуулга ба тодруулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Төсвийн тухай хуулийн 8.9.1 дэх заалт: төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх; заалтыг зөрчин цаг хугацаандаа тайлангаа өгөөгүй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

D:/бичиг хэрэг 2020-Албан тоот А4/

2.1. Оршил

Баянхонгор сумын 2 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг эрхлэгч С.Шүрэнцэцэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын 2 дугаар цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын 2 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.02.25-наас 2020.02.27-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.02.27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор О.Алтансүх хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор сумын 2 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2020.01.08-ны өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Баянхонгор сумын 2 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Хүүхэд эерэг зан чанар, зөв хандлагыг төлөвшүүлэн, бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн чадамжийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Баянхонгор сумын 2 дугаар цэцэрлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор сумын 2 дугаар цэцэрлэгийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Санхүүгийн тооцоолох групп ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн АСОЛОУС болон цалингийн Payroll программ” программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор сумын 2 дугаар цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баянхонгор сумын 2 дугаар цэцэрлэгийн лэгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 34 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 27 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “ дунд,” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 318145,8 мянган төгрөгөөс тооцон 6362,9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор сумын 2 дугаар цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2041,5 мянган төгрөгөөр буюу 0,3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт.

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага		232,6	232,6
Бараа материал	36,350,2	53,714,1	17,363,8
Үндсэн хөрөнгө	584,435,3	578,642,4	-5,792,8
Хуримтлагдсан элэгдэл	-51,778,2	-53026,2	-1248,0
Нийт хөрөнгө	<u>569,007,3</u>	<u>579,563,0</u>	10,555,6
Өглөг	3,9	377,9	374,0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	569,003,4	579,185,1	10,181,6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	<u>569,007,3</u>	<u>579,563,0</u>	10,555,6

Тайлант онд авлага 232,6 мянган төгрөг нэмэгдсэн нь нийгмийн даатгалын шимтгэлийг илүү төлснөөс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 53714,1 мянган төгрөг болж өссөн нь тусгай зориулалтын болон аж ахуй, хүнсний бараа материал авч 17363,8 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл тайлант онд 5792,8 мянган төгрөгөөр буурсан нь Ламын гэгээний 380 жилийн ойн баяр наадмын хандиваас 2019 оны АИТХ-ын

Тэргүүлэгчдийн 98 тогтоолоор 2200,0 мянган төгрөгийн үнэ бүхий 5 ханатай цоохор гэр 1 иж бүрдлийг хандив болгон өгсөн, 356,0 мянган төгрөгийн принтер авч 8348,8 мянган төгрөгийн хөрөнгө акталж данснаас хассантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 9596,8 мянган төгрөгөөр тайлант оны элэгдлийн зардлаар нэмэгдэж 53026,3 мянган төгрөг болсон байна.

Биет бус хөрөнгө нь санхүүгийн программ 750,0 мянган төгрөг, газар 117825,0 мянган төгрөгийн өртөгтэй дансанд бүртгэсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 579185,1 мянган төгрөг болж өмнөх оноос 10181,6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга байхгүй болно.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 70101 хөтөлбөрт зориулан 322825,7 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 282269,2 мянган төгрөгийг улсын төсвөөс, 40556,5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 323428,0 мянган төгрөг буюу 98,9 хувьтай байгаа нь улсын төсвөөс 282269,2 мянга, орон нутгийн төсвөөс 40556,5 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 34 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 27 эрсдэл тодорхойлж нийт 27 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 33810,6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 5882,0 мянган төгрөгийн 2 алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өгч, 3428,6 мянган төгрөгийн алдаанаас тооцож 2428,0 мянган төгрөгийн 1 алдаа зөрчилд төлбөрийн акт тогтоож, 24648,5 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүллээ.

Аудитаар дараах 33810,6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 2428,0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож хүргүүллээ. Үүнд

Илрүүлэлт:

1. Тайланд оны эцэст 3428,6 мянган төгрөгийн хүнсний материалын үлдэгдэлтэй бөгөөд үлдэгдлийг түүвэрлэж тулгахад хүнсний бүтээгдэхүүнийг төсөвтэй харьцуулахад их хэмжээгээр авч хүнсний нөөцийг бэлдсэн байгаа нь хадгалалтын хугацаа алдагдах, чанар байдал өөрчлөлт орох хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал хангахгүй байх эрсдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 45 дугаар зүйлийн “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолын 4-т “Нэг хүүхдэд ногдох дундаж нормативаар санхүүжүүлэх зардлын гүйцэтгэлийг хүүхэд өдрөөр хянаж зөрүүг тооцож байх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

Илрүүлэлт:

Тус байгууллагын 2019 оны жилийн эцсийн байдлаар санхүүгийн тайлангийн бараа материалын тодруулга болон нярвын тайлангийн орлого зарлага зөрүүтэй байгаа нь сар бүр орлого зарлагын бүртэл хийхгүй анхан шатны баримт цаг тухай бүрд нь хөтөлж тайлан гаргаагүй, нягтлан бодогч нярвын тайланд хяналт тавьж, тооцоо бодож акт үйлдээгүй, гарын үсэг зурж баталгаажуулж, тооллогын бүртгэлтэй тулгалт хийж, санхүүгийн программд тайлангаа зөв гаргаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт:

Тайлант онд бодогдсон цалинг нийгмийн даатгалын тайланд 477, 3-мянган төгрөгийг өглөг авлагаар тусгаагүй зөрүүг тооцож арга хэмжээ аваагүй байв.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Бараа материалын тайлангийн үлдэгдэл, гүйлгээ, нягтлан бодогч няравын тайлангийн орлого, зарлагын баримтыг цаг хугацаанд боловсруулж, үлдэглийг баталгаажуулж гаргаж байх. Тухайг байгууллага нь 2019 онд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар аудитад тайланг хугацаа хоцроож аудит хийлгээгүй, 2020 онд хугацааг хоцроож ирүүлсэн, санхүүгийн тайлан дахь үндсэн хөрөнгө, бараа материалын тайлангийн эхний эцсийн үлдэгдэл орлого зарлага зөрүүтэй, тооцоог бодоогүй байгаа тул аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанд Гаргасан тайлан орлого зарлагыг дэлгэрэнгүй анхаарч үзэх шаардлагатай.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор сумын 2 дугаар цэцэрлэгийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 151 мэдээллээс хугацаанд нь 114 мэдээллийг, 37 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй	Тайлбар
1	Бүтэн жил	11	11	9	2		
2	Хагас жил	4	4	3	1		
3	Улирал бүр	1	4	3	1		
4	Сар бүр	3	36	31	5		

5	Тухай бүр	8	96	80	28		
	Нийт	27	151	114	37		

2019 оны тайлант онд дараа жилийн төсвийн төсөл мэдээ, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт мэдээний 9, 11, 12 дугаар сар, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ мэдээний 7, 11-р сар, тухайн жилийн төсөвт нэмэлт өөрчлөлт орсон мэдээний 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 11, 12-р сарууд, санхүүгийн тайлан мэдээний хагас жилийн мэдээ, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл мэдээний 11-р сар, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийн 1, 3-р сар, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэг, хаяг мэдээний 1-8, 11-р сарууд, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, ор, авлага үүсгэсэн аливаа шийдвэр мэдээний 1, 7, 8, 9, 11-р сарууд, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт мэдээний 11 р сар мэдээнүүдийг тус тус хугацаа хоцроосон байна.

Хугацаа хоцроосон тайлбарыг нягтлан бодогчоос авахад алдаатай буруу оруулснаас мэдээллийг аймгийн ЗДТГ-ын СТСХ-ээс шалгаж мэдээллийг засуулж оруулснаас хугацаа хоцроосноор бүртгэгдсэн байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

2019 онд тайлангаа хугацаанд нь ирүүлээгүйгээс аудитад хийлгээгүй.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор сумын 2 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Хязгаарлалтай” дүгнэлт

Баянхонгор сумын 2 дугаар цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Баянхонгор 2 дугаар цэцэрлэгийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

2019 оны тайлант онд цалин болон нийгмийн даатгалын зардлыг бүлэг хооронд зарцуулсан, цалингаас суутгасан суутгал ажил олгогчоос олгох нийгмийн даатгалын шимтгэлийг зөрүүлж дансны бичилт хийж алдаа гаргасан, бодогдсон цалинг нийгмийн даатгалын мэдээнд зөрүүтэй мэдээллсэн. .

1.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх өглөг авлага бүрэн тусгахгүй байх.

1.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8.4 дэх заалтыг хэрэгжүүлж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4 дэх заалтыг хэрэгжүүлэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлт бүрийг санхүүгийн тайланд бүрэн тусгаж, хуулийг мөрдөн ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн алдааг хүлээн зөвшөөрч байна.

2. Балансын данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

2019 оны жилийн эцсийн тооллого хийсэн боловч, нягтлан бодогч тооцоог бодож акт үйлдээгүй, Сангийн сайдын 2018 оны 100 дугаар тушаалын хавсралт НХМаягт БМ-8 батлагдсан маягтын дагуу тооллогын бүртгэл гаргаж баталгаажуулаагүй, тушаалаар

томилогдсон комисс ажлаа тайлагнаагүй, нярвын бараа материалын тайлангийн үлдэгдэл, санхүүгийн тайлангийн үлдэгдэл зөрүүтэй байв.

2.2 Эрсдэл:

Хөрөнгө үрэгдэх

2.3 Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайлан дахь тодруулга, бараа материалын тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг хэрэгжүүлж, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73.4.2-т Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана, гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн тул 2020.05.01-ны дотор тооллого хийж, тооцоог бодож, үр дүнг гаргаж албажуулж, авсан арга хэмжээний талаар хариу ирүүлэх. гэсэн заалтуудыг мөрдөж ажиллах.

2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн алдааг хүлээн зөвшөөрч байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	36,350,259.73	53,947,308.46
33	АВЛАГА	00.00	233,148.78
335	Бусад авлага	00.00	233,148.78
3351	Байгууллагаас авах авлага	00.00	233,148.78
35	БАРАА МАТЕРИАЛ	36,350,259.73	53,714,159.68
351	Түүхий эд материал	23,038,276.73	34,599,226.73
35110	Тусгай зориулалттай материал	22,648,806.73	34,150,056.73
35130	Эм боох материал	389,470.00	449,170.00
354	Хангамжийн материал	13,311,983.00	19,114,932.95
35410	Бичиг хэргийн материал	464,000.00	1,540,800.00
35420	Аж ахуйн материал	2,696,250.00	5,805,700.00
35440	Түлш, шатах тослох материал	1,535,300.50	905,421.50
35450	Барилгын засварын материал	1,583,200.00	1,583,200.00
35460	Хүнсний материал	3,434,182.50	5,680,761.45
35470	Бусад хангамжийн материал	3,599,050.00	3,599,050.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	532,657,090.53	525,616,233.13
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	532,657,090.53	525,616,233.13
392	Биет хөрөнгө	415,075,840.53	408,034,983.13
39201	Барилга, байгууламж, орон сууц	403,518,667.00	403,518,667.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-9,866,718.63	-16,592,029.71
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	30,166,675.00	24,034,335.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-25,456,874.42	-20,773,159.46
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	7,054,535.80	6,587,965.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	-2,989,325.34	-2,755,100.42
39214	Бусад үндсэн хөрөнгө	22,427,913.00	23,233,967.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-12,471,565.56	-11,912,195.76
39217	Ном	2,692,533.68	2,692,533.68
393	Биет бус хөрөнгө	117,581,250.00	117,581,250.00
39301	Програм хангамж	750,000.00	750,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-750,000.00	-750,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	117,825,000.00	117,825,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-243,750.00	-243,750.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	569,007,350.26	579,563,541.59
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,870.00	378,410.50
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,870.00	378,410.50
413	Өглөг	3,870.00	378,410.50
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	262,890.50
4136	Бусад өглөг	3,870.00	115,520.00
41361	Байгууллагад төлөх өглөг	3,870.00	115,520.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	569,003,480.26	579,185,131.09

51	Засгийн газрын хувь оролцоо	569,003,480.26	579,185,131.09
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	181,448,936.00	181,448,936.00
51101	Өмч: - төрийн	181,448,936.00	181,448,936.00
512	Хуримтлагдсан үр дүн	-11,323,142.04	-1,141,491.21
51210	Өмнөх үеийн үр дүн	-11,323,142.04	-11,323,142.04
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	10,181,650.83
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	398,877,686.30	398,877,686.30
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	569,007,350.26	579,563,541.59

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	284,191,958.73	328,327,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,194,672.73	2,200,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	16,194,672.73	2,200,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	16,194,672.73	2,200,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	14,738,672.73	2,200,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,162,786.00	43,858,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	261,834,500.00	282,269,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	3,301,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	3,301,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00*	40,556,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	40,556,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	271,360,649.09	318,145,849.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	271,360,649.09	318,145,849.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	257,454,691.76	314,222,976.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	148,606,654.10	189,941,590.00
210101	Үндсэн цалин	134,233,597.10	163,478,393.00
210102	Нэмэгдэл	6,400,476.00	12,910,900.00
210104	Урамшуулал	7,972,581.00	13,552,297.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,730,428.00	23,045,251.72
210201	Тэтгэврийн даатгал	11,373,228.00	13,712,897.28
210202	Тэтгэмжийн даатгал	1,106,700.00	1,625,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	250,500.00	1,396,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	680,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	5,629,654.44

Баянхонгор сумын 2 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210203	ҮОМШӨ-ний даатгал	250,500.00	1,396,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	680,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	5,629,654.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,788,491.00	37,708,844.00
210301	Гэрэл, цахилгаан	2,974,143.00	3,709,788.00
210302	Түлш, халаалт	21,978,000.00	23,860,000.00
210303	Цэвэр, бохир ус	10,836,348.00	10,139,056.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,713,830.50	4,938,592.00
210401	Бичиг хэрэг	920,140.00	608,500.00
210402	Тээвэр, шатахуун	215,000.00	969,879.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	896,590.50	1,344,313.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	135,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	565,100.00	796,400.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	117,000.00	1,084,500.00
2105	Нормативт зардал	44,086,575.00	44,901,741.05
210502	Хоол, хүнс	44,086,575.00	44,680,741.05
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	221,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	2,218,800.00
210604	Урсгал засвар	00.00	2,218,800.00
2107	Томилолт, зочны зардал	84,300.00	263,800.00
210702	Дотоод албан томилолт	84,300.00	263,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	798,452.00	1,603,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	798,452.00	1,603,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,645,961.16	9,601,357.40
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	117,500.00	4,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	11,281,528.16	9,596,857.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,905,957.33	3,922,873.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,171,986.00	3,429,800.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	11,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	6,831,200.00	3,301,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	178,000.00	117,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	47,656.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	47,656.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	445,417.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	445,417.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	12,831,309.64	10,181,650.83
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	12,831,309.64	10,181,650.83

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	269,453,286.00	326,197,669.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	267,997,286.00	326,197,669.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	261,834,500.00	282,269,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	3,301,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	3,301,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	40,556,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	40,556,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	6,162,786.00	70,169.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	6,162,786.00	70,169.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	269,453,286.00	325,841,669.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	269,453,286.00	325,841,669.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	255,507,728.67	321,848,627.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	139,220,342.00	189,942,090.50
210101	Үндсэн цалин	124,870,244.00	163,478,893.50
210102	Нэмэгдэл	6,179,977.00	12,910,900.00
210104	Урамшуулал	8,170,121.00	13,552,297.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,423,500.00	23,277,900.00
210201	Тэтгэврийн даатгал	16,107,842.00	16,297,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,318,758.00	1,745,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,067,500.00	1,396,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	260,700.00	348,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,668,700.00	3,490,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,288,491.00	37,708,844.00
210301	Гэрэл, цахилгаан	2,651,292.00	3,709,788.00
210302	Түлш, халаалт	22,800,851.00	23,860,000.00
210303	Цэвэр, бохир ус	10,836,348.00	10,139,056.00

2104	Хангамж, бараа материалын зардал	3,684,482.50	3,740,762.50
210401	Бичиг хэрэг	108,140.00	111,000.00
210402	Тээвэр, шатахуун	935,000.00	340,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,041,042.50	1,344,312.50
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	235,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,527,800.00	1,710,450.00
2105	Нормативт зардал	48,048,681.50	52,515,830.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	42,120.00	59,700.00
210502	Хоол, хүнс	45,991,361.50	46,664,430.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,015,200.00	5,791,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,020,580.00	8,194,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,090,000.00	2,480,000.00
210604	Урсгал засвар	930,580.00	5,714,600.00
2107	Томилолт, зочны зардал	84,300.00	119,500.00
210702	Дотоод албан томилолт	84,300.00	119,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	654,000.00	1,503,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	654,000.00	1,503,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,083,351.67	4,846,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	112,500.00	4,846,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,945,557.33	3,993,042.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,211,586.00	3,499,969.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	00.00	70,169.00
213208	Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	6,831,200.00	3,301,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	217,600.00	128,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	47,656.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	47,656.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	445,417.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	445,417.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	356,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	356,000.00

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	356,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	356,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	356,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-356,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	181,448,936.00	398,877,686.30	-11,323,142.04	569,003,480.26
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	181,448,936.00	398,877,686.30	-11,323,142.04	569,003,480.26
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	181,448,936.00	398,877,686.30	-11,323,142.04	569,003,480.26
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	10,181,650.83	10,181,650.83
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	181,448,936.00	398,877,686.30	-1,141,491.21	579,185,131.09

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	322,825,700.00	323,428,013.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	322,825,700.00	323,428,013.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	322,697,700.00	323,300,013.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	190,023,000.00	191,037,477.00
210101	Үндсэн цалин	163,551,000.00	164,574,280.00
210102	Нэмэгдэл	12,917,300.00	12,910,900.00
210104	Урамшуулал	13,554,700.00	13,552,297.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,277,900.00	23,277,900.00
210201	Тэтгэврийн даатгал	16,297,600.00	16,297,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,745,100.00	1,745,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,396,100.00	1,396,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	348,900.00	348,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,490,200.00	3,490,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,756,500.00	37,708,844.00
210301	Гэрэл, цахилгаан	5,499,000.00	3,709,788.00
210302	Түлш, халаалт	21,411,500.00	23,860,000.00
210303	Цэвэр, бохир ус	10,846,000.00	10,139,056.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,908,300.00	3,740,762.50
210401	Бичиг хэрэг	115,200.00	111,000.00

Баянхонгор сумын 2 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210402	Тээвэр, шатахуун	340,000.00	340,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,300,700.00	1,344,312.50
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	235,000.00	235,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,853,400.00	1,710,450.00
2105	Нормативт зардал	52,521,600.00	52,515,830.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	59,700.00	59,700.00
210502	Хоол, хүнс	46,665,000.00	46,664,430.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,796,900.00	5,791,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,194,600.00	8,194,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,480,000.00	2,480,000.00
210604	Урсгал засвар	5,714,600.00	5,714,600.00
2107	Томилолт, зочны зардал	119,500.00	119,500.00
210702	Дотоод албан томилолт	119,500.00	119,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,690,200.00	1,503,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,690,200.00	1,503,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5206100.00	5202100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,206,100.00	5,202,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	128000.00	128000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	128,000.00	128,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	128,000.00	128,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	322,825,700.00	322,332,627.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	282,269,200.00	281,823,783.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	282,269,200.00	281,823,783.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	40,556,500.00	40,508,844.00
132001	Орон нутгийн төсвөөс	40,556,500.00	40,508,844.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	18.00	18.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	10.00
620003	Үйлчлэх ажилтан	07.00	07.00

Аудитын тайланг

Хясан:

Тэргүүлэх аудитор  Б.Мөнхбат 2018.02.27

Аудитын менежер  А.Цээням 2018.02.27

Бэлтгэсэн:

Аудитор  О.Алтансүх 2018.02.27

